

Засагт хан аймгийн Баатар засгийн хошууны хүн амын овгийн бүрэлдэхүүн

Баасанхүүгийн Батмөнх^{1,*}

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд Засагт хан аймгийн Баатар засгийн хошууны халхчуудын дотор бүртгэгдсэн овгуудын талаар өгүүлжээ. Тус хошуунд Авга, Алаг адуутан (Алаг адууныхан), Баарин, Баатад, Багш хиа нар, Боржигин, Бэсүд, Горлос, Дайчин, Дөчин, Еншөөбүү (Огтор Еншөөбүү), Жалайр, Зуухныхан, Их мянган, Олхонууд, Өөлд, Өрлөгчүүд (Өрлөгүүд), Сартуул, Тангуд, Тугчин, Тугтан, Урианхай, Хойд, Хорхой нүдэн, Хотгойд, Цахар зэрэг овгийнхон аж төрсөөр ирсэн байна.

Түлхүүр үг: Засагт хан аймаг, Баатар засгийн хошуу, хүн ам, овог

Удиртгал

Засагт хан аймгийн Баатар засгийн хошуу 1691 онд байгуулагдсан Засагт хан аймгийн анхны хошуудын нэг болно. Өнөөгийн байдлаар Баатар засгийн хошууны халхчуудын овгийн судалгаа харьцангуй бага хийгджээ. Иймд тэдний овгийн бүрэлдэхүүнийг судлан тодруулах нь угсаа гарал, түүх соёлын асуудлуудыг нэхэн тодруулахад чухал ач холбогдолтой.

Баатар засгийн хошуунд ямар ямар овгууд байсан талаар зарим судлаачид бичсэн байна. Академич Б.Ринчений удирдлагаар эрхлэн хэвлүүлсэн “Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас”-г: Говь-Алтай аймгийн Хөхморьт, Баян-Уул сумдаас Жалайр, Бэсүд, Олхонууд, Боржигин, Тангуд, Тугтан, Урианхан зэрэг овгуудыг тэмдэглэсэн байна (Монгол ард 1979: 53, 56, 59, 63, 66-68).

Эрдэмтэн С.Бадамхатаны удирдлагаар эрхлэн хэвлүүлсэн “Халхын угсаатны зүй” зохиолд хуучны Засагт хан аймгийн Баатар засгийн хошууны нутаг буюу өнөөгийн Говь-Алтай аймгийн Хөхморьт суманд Бэсүд, Баян-Уул суманд Бэсүд, Их мянган зэрэг овгууд буйг бүртгэжээ (БНМАУ-ын угсаатны зүй 1987: 46-47).

Профессор А.Очир, Ж.Сэржээ нар Говь-Алтай аймгийн Хөхморьт суманд Авга, Баарин, Боржигин, Бэсүд, Еншөөбүү, Олхонууд, Өөлд, Сартуул, Урианхай, Хойд, Жалайр зэрэг овгууд, Баян-Уул суманд Баатад, Багш нар хиа, Боржигин, Бэсүд, Дайчин, Жалайр, Зуухныхан, Еншөөбүү, Огтор Еншөөбүү, Өрлөгүүд, Тангуд, Тугчин, Тугтан, Урианхай, Хар тугчин, Хойд, Хорхой нүдэн, Хотгойд, Цахар зэрэг овгууд буйг тус

тус тэмдэглэсэн байна (Тайжиуд Аюудайн Очир нар 1998: 16-17, 43-46).

Түүхч Ц.Сономдагва Засагт хан аймгийн Баатар засгийн хошуунд Боржигин, Олхонууд, Авга, Баатад, Багш хиа нар, Бэсүд, Горлос, Дөчин, Жалайр, Зуухныхан, Еншөөбүү, Огтор Еншөөбүү, Өөлд, Өрлөгүүд, Сартуул, Тангуд, Тугтан, Урианхай, Хартугчин, Хойд, Хорхой нүдэн, Хотогойд, Шахар зэрэг овгууд буйг тэмдэглэжээ (Сономдагва 1998: 262).

Зохиолч, сэтгүүлч Л.Мөнхтөр Засагт хан аймгийн Баатар засгийн хошуунд Авга, Баарин, Боржигин, Бэсүд, Жалайр, Йөншөөбүү, Олхонууд, Өөлд, Сартуул, Урианхай, Хойд зэрэг овгууд байсан талаар дурджээ (Мөнхтөр 2024: 378).

Ийнхүү дээр өгүүлсэн судалгаанаас өөр Баатар засгийн хошууны хүн амын овгуудыг судлан шинжилсэн зүйл хараахан үгүй. Ингээд эл өгүүлэлд Засагт хан аймгийн Баатар засгийн хошууны халхчуудын овгийн бүрэлдэхүүний талаар өгүүлжээ.

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй

Бид 2011, 2018, 2021 онд хуучин Засагт хан аймгийн Баатар засгийн хошуу буюу өнөөгийн Говь-Алтай аймгийн Хөхморьт, Баян уул сумдын нутагт угсаатны судлалын хээрийн судалгаа хийж, овгуудыг судлан тодруулах оролдлого хийлээ. Судалгааг боловсруулахад баримталсан зарчим бол хээрийн шинжилгээгээр цуглуулсан хэрэглэгдэхүүнийг сурвалж бичиг, судалгааны баримт, мэдээ, санал, дүгнэлттэй харьцуулан, үзэгдлийн учир шалтгаан, мөн чанарыг тодруулахад анхаарч ажиллав. Өгүүллийг бичихдээ анализ, синтез, бичиглэлийн болон харьцуулалтын аргуудыг хэрэглэсэн болно.

¹ МУИС-ийн Баруун бүсийн сургууль

* Холбоо барих зохиогч: batmunkhbaasankhuu09@gmail.com
<https://orcid.org/0000-0002-5966-6873>

Хэлэлцүүлэг

Судлаачид өнөөгийн байдлаар Баатар засгийн хошуунаас Авга, Алаг адуутан (Алаг адууныхан), Баарин, Баатад, Багш хиа нар, Боржигин, Бэсүд, Горлос, Дайчин, Дөчин, Еншөөбүү (Огтор Еншөөбүү), Жалайр, Зуухныхан, Их мянган, Олхонууд, Өөлд, Өрлөгчүүд (Өрлөгүүд), Сартуул, Тангуд, Тугчин, Тугтан, Урианхай, Хойд, Хорхой нүдэн, Хотгойд, Цахар зэрэг овгуудыг бүртгээд байна.

Авга: Засагт хан аймгийн Баатар засгийн хошуунд энэ овог бүртгэгдсэн байна (Сономдагва 1998: 262). Монголчууд аавын ах, дүү, хамаатан садныг “авга” хэмээн нэрлэдэг. Профессор А.Очир авга нь аав+ах (abu+aq-a) гэдэг хоёр үг нийлж хэвшсэнээс үүссэн хүний эшийн нэр хэмээн бичжээ (Очир 2012: 7).

Алаг адуутан (Алаг адууныхан): Энэ овог Засагт хан аймгийн Баатар засгийн хошууны хүн амын дотор бүртгэгдсэн байна. Монголчуудын доторх алаг адуутан овог нь Байгал нуурын өмнө, баруун биеэр нутаглаж асан эртний алаг адуун нарын хойчис буй заа. Алаг адууныхан, алаг адуутан нар нь Сартуул, Урианхан, Баруун Халхчуудын дунд голлон тархжээ. Энэхүү нэр нь алаг, адуун гэсэн хоёр үгээс нийлж бүтжээ (Очир 2012: 10).

Баарин: Баарин овогтон хуучны Засагт хан аймгийн зарим хэсэг буюу өнөөгийн Говь-Алтай, Ховд аймгийн халхчуудад бүртгэгдээд байна. Баарин хэмээх үг нь баар, бааруу, баараг гэсэн үгтэй язгуур утгаараа нийцнэ. Тодруулбал, Баарин хэмээх нэр нь монгол хэлний хольцоотой, цэвэр биш, жинхэнэ биш гэсэн утгатай баар (баарах, баартах, баараг) гэсэн үгээс үүсэлтэй бололтой (Очир 2012: 20).

Баатад: Чингис хаан 1206 онд Их Монгол улсыг байгуулж, төр-цэргийн зохион байгуулалтыг шинэчлэхдээ, хааны орд өргөө болоод амийг сахих нэг түмэн хишигтний дотор нэг мянган ялгасан Баатудыг буй болгоод, Архай Хасараар захируулжээ. Хишигтний доторх тэр нэгэн мянган Баатудын үр удам нь яваандаа Баатуд овогтон болов. Өөрөөр хэлбэл, цэрэг захиргааны байгуулалтаас энэ овог үүсчээ (Очир 2012: 20-21).

Баатуд нь баатар гэсэн үгэнд олон тооны-д нөхцөл залгаж үүссэн бололтой. Өдгөө Баатуд нар Монгол улсын Архангай, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн олон сумуудад тархан суусан байна (Очир нар 1998: 10-19, 34-50).

Багш хиа нар: Энэ овгийг зарим судлаач Говь-Алтай аймгийн Баян-Уул, Шарга сумаас бүртгэсэн бөгөөд эрхэлсэн ажил, мэргэжлээр нэрийдсэн үржвэр овог гэж бичжээ (Очир 2012: 21).

Боржигин: Баатар засгийн хошууны доторх

Боржигин овог нь тэднийг захирч явсан ноёд тайж нарын удам юм. Баатар засгийн хошууны засаг ноёд бүгд Боржигин овогтон байжээ. “Зарлигаар тогтоосон Монгол улсын шастирын хураангуй”-д: “... Засагт хан аймгийн чин ван Базарваань. Юан улсын Тайзу хааны үр Гэрсэнз жалайр хун тайжийн залгамжир, Боржигэд овог, Хиуд яс” (Зарлигаар тогтоосон 1997: 122) хэмээн тэмдэглэжээ.

“Монголын нууц товчоо”-нд: “Бодончар Боржигин овогтон болов” (МНТ. 2011: 12) гэж бичжээ. Бодончар бол X зууны үеийн язгуурын монголчуудын тэргүүлэгч агсан Добу мэргэн нас нөгцсөний дараа түүний бэлэвсэн үлдсэн хатан Алунгоогоос төрсөн гурван хүүгийн отгон нь билээ. Тийнхүү Бөртэ Чоноос эхэлсэн язгуурын монголчуудын нэгэн салбарын ноёдын удам нь X зууны үед Добу мэргэнд хүрээд тасрав. Тийм учраас хожмын Монголын их хаадын удмыг Бөртэ чоноос биш, харин Бодончараас эхлүүлэн тоолдог. Дээрхээс үзвэл Боржигин овог нь X зууны сүүлчээр үүссэн байж болох юм.

Бодончараас эх үүсгэл нь тавигдсан алтан ургийн Боржигин ноёд XIII-XIV зууны үед Монголын эзэнт гүрний, XIV зууны хоёрдугаар хагасаас XVIII зуунд зүүн Монголын бүх эрхийг барьж байлаа. Чингис хаан XIII зууны эхэн үед өөрийн дүү, хүүхдүүддээ Монгол орныг хуваан өмч өгснөөр тэдний үр хойчис нь залгамжлан, Монгол улсын хүн ам, газар нутгийн тодорхой хэсгийг өвлөсөөр иржээ. Манж Чин улсын эрхшээлийн үед боржигины язгууртнуудын төр барих эрх хасагдсан боловч орон нутгийн эрх баригсдын дийлэнх олонх нь Боржигин овогтон байв. Тэр үеийн Боржигин тайж нар нь уг гарлаараа бүгд Чингис хаан, түүний дүү нарын үр хойчис юм. XVIII-XX зууны эхэн үед Боржигин овгийн тайж нарыг дотор нь төрөл тайж, харьяат тайж хэмээн хоёр хуваадаг. Чингис хааны шууд угсааныхныг “төрөл тайж”, Чингис хааны дүү нарын үр хойчисыг “харьяат тайж” гэнэ.

XVIII-XX зууны эхэн үеийн Боржигин овогт тайж нарын эзэмшлийг дурдвал: Чингис хааны отгон хүү Тулуйн угсааны Батмөнх даян хааны отгон хүү Гэрсэнзийн үр хойчис нь Халхын Түшээт хан, Сэцэн хан, Засагт хан, Сайн ноён хан аймгийн 83, мөн Хөхнуурын 1, Өвөр Монголын Зуу-удын чуулганы Халхын зүүнгарын 1, Өвөр монголын Улаанцавын чуулганы Халхын баруун гарын 1, бүгд 86 хошууны засаг ноёд байв.

Боржигин нэрийн гарлыг профессор А.Очир дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд: Монгол, түрэг угсаатны дунд Чоно, Чонос нэрт овог маш эртнээс байсаар иржээ. Одоо ч монголчуудын дунд түүнтэй утга тэнцэх бүрд буюу бурд овог хадгалагджээ. Энэхүү Бүрд буюу Бурд хэмээх овгийн нэр нь алтай хэлний бөри, бүригийн олны дагавар зүүсэн хэлбэр юм. Эрт цагт алтайн хэлнээ чоныг бөри бүри гэж нэгэн адил

нэрлэж байжээ. Монголчууд хожим хүртэл чонын бэлтрэгийг бөртэ гэж нэрлэж байсан нь түүний үлдэц бөгөөд бөри, бору гэдэг хоёр үг гарлын холбоотойг давхар үзүүлнэ. Боржигин гэдэг нэрийн сүүлчийн жигин-ий хувьд гэвэл, эртний алтайн хэлний тегин гэсэн үгийн хожмын монгол хувилбар аж. Ийнхүү чоно тахиглан шүтэгчдийн онгон сүлдний нэр нь яваандаа өөрсдийнх нь овгийн нэр болсон гэлтэй (Очир 2012: 52-53).

Бэсүд: Бэсүд нь язгуурын монголчуудын нэгэн аймаг юм. “Монголын нууц товчоо”, “Судрын чуулган” зэрэг сурвалжийн мэдээг үндэслэвэл, Бэсүд нар Чингис хааны дээд өвөг Хайду ханы үр, ач нарын үед тэдний харьяат аймаг болж анх үүссэн бололтой (МНТ 2011: 13). Зарим судлаачийн үзсэнээр Хайду хан нь XI-XII зууны зааг үеийн хүн ажээ. Иймд Бэсүд аймаг XI зууны эцсээр үүссэн гэмээр байна.

1206 онд Чингис хаан Бэсүд аймгаас бүрдсэн нэг мянганыг Отчигин ноёны мэдэлд өгсөн ажээ. Чингис хааны отгон дүүд очсон тэрхүү Бэсүд нар бөөн бүлгээрээ Монголын алтан ургийнхны захиргаанд явсаар, XVI зуунаас Гэрсэнзийн дэд хүү Ноёнтойн эзэмшилд очив

Халхын арын долоон отгийн бүрэлдэхүүнд очсон дээрх Бэсүд нар XVII зуунд Хангайн нуруугаар нутаглан агснаа XVII зуунд Алтайн уулсын зүүн урд биеэр очиж, Халхын Засагт хан аймагт захирагдан суужээ. Манжийн эрхшээлийн үед тэднийг “Бэсүд таван хошуу” хэмээн нэрлэж байв. “Энэ нэгэн дэвтэр амуй” хэмээх сурвалж-д: “...Таван бэсүд нь Засагт хан, гүн Жигмэддорж, бэйсийн зэрэг гүн Цэдэндондовдорж, засаг Цэрэндорж, засаг Маньбадара тав” (Энэ нэгэн 2006: 29) гэж тэмдэглэжээ. Бэсүд таван хошуу нь Засагт хан аймгийн Засагт ханы хошуу, Илдэн засгийн хошуу, Жонон засгийн хошуу, Ёст засгийн хошуу, Бишрэлт засгийн хошуу зэрэг болно.

1912 онд Ёст засгийн хошууг тасалж, Итгэмжит засгийн хошууг байгуулснаар Бэсүд зургаан хошуу болжээ. Зургаан хошууны засаг ноёд нь цөм Ноёнтойн үрс мөн хэмээдэг. ХҮІ зууны дундаас ХХ зууны эхэн хүртэл Бэсүд нарын ихэнхийг Ноёнтойн үр хойчис тасралтгүй захирсаар ирэв.

Бэсүд зургаан хошуугаар өнөөгийн Монгол улсын Говь-Алтай аймгийн Тайшир, Дэлгэр, Халиун, Чандмань, Эрдэнэ, Цогт, Цээл, Алтай; Баянхонгор аймгийн Шинэжинст, Баянговь, Баянцагаан, сум бүтэн, Баян-Өндөр сумын баруун тал; Өмнөговь аймгийн Гурвантэс сумын баруун хэсгийг байгуулсан аж. Бас Бэсүдийн зарим нь Гэрсэнзийн ууган хүү Ашихай дархан ноёны угсааны ноёдод захирагдаж явсан байна. Бэсүдийн цөөнх зарим нь Гэрсэнзийн ууган хүү Ашихайн удмын ноёдод захирагдаж яваад хожим нь хотгойд нартай хольцолдон, Хөвсгөл, Завхан аймгуудын баруун талын сумдад суужээ (Очир

2012: 72-73).

Бэсүд хэмээх нэр нь ес гэсэн тооны нэрээс үүссэн бололтой. Судрын чуулганд Бэсүд гэдгийг Ийсүд гэж бичжээ. Ийсүд нь ес гэсэн үгийн олны хэлбэр ес+үд-есүд мөн байлтай (Очир, Гэрэлбадрах 2003: 114).

Бэсүд овогтон хуучин Засагт хан аймагт нэлээд тархсан байдалтай байна. Бидний судалгааны явцад эдүгээ Говь-Алтай аймгийн Хөхморьт, Баян-Уул, Жаргалан, Ховд аймгийн Дарви, Чандмань суманд бүртгэгдэж байна.

Горлос: Язгуурын монголчуудын Дарлигины бүлэгт багтаж явсан эртний аймаг. Горлос овог Засагт хан аймгийн Баатар засгийн хошуунд байсан тухай Ц.Сономдагва абугай дурджээ (Сономдагва 1998: 262).

XII зууны үед тэд Хонхирад, Ихэрс нартай зах залган Хянганы нурууны баруун этгээдээр нутаглаж, Хамаг Монголын Хадаан тайж, Хотола нарын харьяат байж байгаад XII зууны эцсээр Тэмүжин Тайчууд аймаг, Жадараны Жамуха нартай тэмцэлдсэн цагт Горлос нарын зарим нь Тэмүжинг дагажээ. Зарим нь Жамухыг даган Тэмүжинтэй байлдаж дийлдэн, түүний эрхшээлд оров. 1206 онд Их Монгол улсыг байгуулахад Өүлэн эхийн мэдэлд очсон мянгатуудын 3000 өрх нь Горлос, Олхонууд нараас бүрдэж байжээ. Зарим нь Хавт Хасарын мэдэлд очсон бололтой. Өүлэн эхэд очсон Горлос нар Монголын хаадын үр хойчид захирагдан явсаар XVI зууны дундуур Халхын арын долоон отгийн бүрэлдэхүүнд багтаж, улмаар XVII зууны сүүл үеэс Хэрэгүд (Хиргис) нарын хамт Халхын Түшээт хан аймгийн бүрдүүлжээ. 1725 онд Түшээт хан аймгаас таслан Сайн ноён хан аймгийг байгуулахад Горлос нар Түшээт хан аймгийг, Хэрэгүд нар нь Сайн ноён хан аймгийн хүн амыг голлон бүрдүүлсэн байдаг (Очир 2002: 75-76).

Горлос хэмээх нэрийг профессор А.Очир: “...Тэд Байгаль нуур хавьд нутаглан агсан Хори-түмэдээс тасран нүүхдээ үүсгэсэн Хорилар хэмээх овгийн нэр нь яваандаа хорилар-хорилас-горилас-горалас-горлас-горлос хэмээн хувирсан бололтой” (Очир 2012: 77) гэжээ.

Дайчин: Энэ овог Баатар засгийн хошуунд байсан талаар А.Очир, Ж.Сэржээ, Ц.Сономдагва нар бүтээлдээ дурдсан байна (Очир, Сэржээ 1998: 16-17; Сономдагва 1998: 262).

Дөчин: Баатар засгийн хошуунд энэ овог байсан талаар А.Очир, Ж.Сэржээ, Ц.Сономдагва нар бүтээлдээ дурджээ (Очир, Сэржээ 1998: 16-17; Сономдагва 1998: 262).

Еншөөбүү (Огтор Еншөөбүү): Засагт хан аймгийн Баатар засгийн хошуунд Еншөөбүү нар сууж байжээ. Юань улсын үед хааны ордны хэрэгцээт албыг гүйцэтгүүлэхээр янз бүрийн аймаг, овгийн хүмүүсийг татан авч, нэгтгэн байгуулсан газрын нэр

нь хожим тэнд ажиллаж агсан хүмүүсийн аймгийн нэр болсноор, Эншөөбүү хэмээх нэр үүссэн бололтой. Эншөөбүү овогтон Монгол улсаас гадна ОХУ-ын Буриад, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Оронд тархан суужээ.

Засагт хан аймгийн Баатар засгийн хошуунд Эншөөбүү нарыг Отгор Эншөөбүү хэмээн нэрлэсээр ирэв. Энэ нэр хэрхэн үүссэн тухай нэгэн домог ам дамжин яригдсаар иржээ. Нэгэн наадамд Эншөөбүү нар морьтойгоо очжээ. Ингээд морь уралдуулахдаа мориныхоо сүүлийг боогоогүй байж гэнэ. Мориныхоо сүүлийг боогоод ирж гэнэ. Гэтэл тэд сүүлийг боолгүй богиносгоод хайчилжээ. Үүнээс үүдээд Отгор Эншөөбүү хэмээх нэр бий болсон гэнэ.

Жалайр: XII зууны эцэс XIII зууны эхэн үед Жалайрууд Чингисийн 13 хүрээний нэг болж, Их Монгол улс, Монголын эзэнт улсыг байгуулахад хүчин зүтгэж явсан аж. Мянганы мянгаахад Жалайр аймгаар 7 мянган байгуулсан бөгөөд түүний хоёр нь баруун жигүүрт, дөрвөн нь зүүн жигүүрт багтсан аж. Харин нэг хэсэг нь Чингис хааны гутгаар хүү Өгөдэйн мэдэлд очсон байна. Монголчуудын баруунш хийсэн дайны үед Жалайр нарын зарим нь Цагадай, Ил хаад, Алтан ордны улсуудад тархан суурьшжээ. Чингис хааны алтан ургийнхны харьяанд захирагдсан Жалайр нарын ихэнх нь XVI зууны дундуур Батмөнх даян хааны ууган хүү Ашихайн харьяанд оров. Мөн зарим нь Чингис хааны дүү Хавт Хасарын угсааны ноёдод захирагдаж яваад, Жалайд нэр зүүж, Өвөр Монголд хоёр хошуу болж суурьшжээ.

Халхын арын долоон отгийн бүрэлдэхүүнд багтаж, Ашихайн эзэмшилд очсон Жалайр нар XVI зууны сүүл хагаст Хангай уулаар нутаглаж байлаа. XVII зууны эхээр Алтай ууланд хүрч нутаглаж байгаад тэднийг захирсан ноён Цэвээнжав Манж Чин улсын цэрэгт хүчин зүтгэхээс татгалзсаны учирт шийтгүүлж, Жалайр нарыг тараан суулгажээ. XVIII зууны эхээр Жалайр нар бие даасан угсаатны бүлгийн шинж байдлаа алдаж, Ар Монголд цацагдаж суугаад өөрсдийгөө Жалайр овогтон гэх болжээ (Очир 2012: 220-221).

Зуухныхан: Эл овгийг судлаачид урьд өмнө бүртгэсэн байна. Угсаатны судлалын хээрийн судалгааны явцад миний бие Говь-Алтай аймгийн Баян-Уул суманд Зуухныхан овгийн хүнтэй уулзав. Зуухныхан нэг эрэгтэй хүүхэдтэй айл байсан гэнэ. Гал манана гэдэг. Түүнээс салбарласан овог хэмээн ярьж байлаа.

Их мянган: “Илтгэл шаштир” тэргүүтний мэдээг хянан үзвэл, Дөрвөн Ойрадын Хойд аймгийн ноёд, тайж нар голдуу Их мянган овогтой байсан нь мэдэгдэнэ. Профессор А.Очир: “...XIII зууны эхэн үед Ойрадуудаар дөрвөн мянган байгуулаад, Хутаг бэхи ноёд тэднийг ерөнхийд нь захируулсан билээ. Тэр

дөрвөн мянганы дотор Хутуга бэхи, түүний удмынхны шууд харьяалан захирдаг нэгэн мянган байсан нь мэдээж. Тэр мянганыг их мянган хэмээх нэрлэж байсан бололтой. Түүний нэрийн их гэдэг нь тэргүүн, гол, үндсэн гэсэн утгатай. Энэ нь хожим Чин гүрний үед халхын хан нарын шууд харьяалан захирсан хошууг гол хошуу хэмээдэг байсантай адилшаалтай юм” (Очир 2012: 110-111) хэмээн бичжээ.

Бидний судалгааны явцад Их мянган овог Говь-Алтай аймгийн Баян-Уул, Жаргалан суманд буй нь мэдэгдэнэ. Өөрсдийнхөө угсаа гарлын талаар тодорхой зүйл ярьсангүй. Тэд Засагт хан аймгийн Сүжигт засгийн хошуунаас Үйзэн засаг, Баатар засгийн хошуунд орж ирж нутагшсан байж болох юм. Учир нь Сүжигт засгийн хошуунд Хойдууд аж төрж, тус хошууг Засагт хан аймагт хавсрагдсан Хойд хошуу хэмээн нэрийдэж байсан билээ.

Олхонууд: Олхонууд нь язгуурын монголчуудад багтаж явсан эртний аймаг юм. XIII зууны эхээр Их Монгол улс байгуулагдахад Чингис хааны эх Өүлэн хатны мянганд Олхонууд багтжээ. Өүлэн эхийн мэдэлд очсон Олхонууд нар тэр цагаас Чингис хааны үр ач нарт захирагдан явсаар XV зууны үед баруун тийш нүүдэллэн, Хангай ууланд хүрчээ. XVI зууны дунд үед тэд Гэрсэнзийн ууган хүү Ашихай дарханы мэдэлд очсон байна. Чингис хааны ач Ашихай дарханд очсон Олхонууд нар XVI зууны сүүл XVII зууны эхэн үеэр Алтай уулын ар, Завхан голын урдуур очиж, халхын Засагт хан аймгийн гурван хошуу болж суурьшжээ (Очир 2012: 147).

Олхонуудын тархацаас үзвэл, тэд хүн ам олонтой том аймаг байгаад XIII зуунаас хойш тархан сарниж олон газар хуваагдан суужээ. Олхонууд нар түүхийн явцад бусад монголчуудын дунд цөөн цөөнөөр орж суурьшсан байна. Одоо Архангай аймгийн Цэцэрлэг, Тариат, Хангай, Чулуут, Өндөр-Улаан, Их Тамир; Баянхонгор аймгийн Заг, Галуут, Баян-Овоо, Бөмбөгөр, Хүрээ марал; Булган аймгийн Тэшиг, Сэлэнгэ; Говь-Алтай аймгийн Дарви, Тонхил, Тайшир, Бугат, Дэлгэр, Бигэр, Чандмань, Эрдэнэ, Цогт, Цээл; Дорноговь аймгийн Улаанбадрах, Хөвсгөл, Мандах; Дундговь аймгийн Сайхан-Овоо, Дэлгэрхангай, Хулд, Өлзийт, Луус, Эрдэнэдалай, Сайнцагаан, Дэрэн; Завхан аймгийн Их-Уул, Отгон, Шилүүстэй; Өвөрхангай аймгийн Бүрд, Төгрөг, Баянгол, Сант; Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Цогтцэций, Манлай; Сэлэнгэ аймгийн Түшиг, Цагааннуур; Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл, Их-Уул, Тариалан, Жаргалтхаан (Очир 2012: 149), Ховд аймгийн Дарви, Чандмань, Буянт, Мөст, Цэцэг сумдад Олхонууд овогтон бөөнөөр болон хэсэг бүлгээр аж төрж байна.

Эрдэмтэн Ш.Гаадамба Олхонууд нь дов, толгой гэсэн утгатай олхоу хэмээх үгээс гаралтай (МНТ 1990: 247) гэж үзжээ. Олхонууд нь дов, толгой гэсэн

утга бүхий олхон гэсэн үгэнд олны-ууд нөхцөл залгаж бүтээсэн нэр бололтой.

Засагт хан аймгийн Олхонууд гурван хошууны нутаг нь өнөөгийн Монгол улсын ямар аймгийн ямар сум болохыг дурдваас: Баатар засгийн хошуу нь Говь-Алтай аймгийн Баян-Уул, Хөхморьт сум бүтэн, Үйзэн засгийн хошуу нь Говь-Алтай аймгийн Жаргалан сум, Эрдэнэ засгийн хошуу нь Ховд аймгийн Дарви, Чандмань сумдын нутаг болно. "Энэ нэгэн дэвтэр амуй" хэмээх сурвалж-д: "...Гурван Олгонуд нь түшээ гүн Аюур, түшээ гүн Дамдинсүрэн, засаг Сономцэрэн энэ гурав Ашихайн ахмад хөвгүүн Баяндара тайжийн үрс мөн" (Энэ нэгэн 2006:29) гэж тэмдэглэжээ.

Өөлд (Их өөлд, бага өөлд): Судлаачид Өөлд, их Өөлд, бага Өөлд овгийг Говь-Алтай аймгийн Хөхморьт, Баян-Уул, Жаргалан сумдад бүртгэсэн байна.

Тод үсгийн сурвалжийн мэдээг эш болговол, Эсэн хааны ач Хамаг тайш 1480-аад оны үед Цоросын дотроос албат таслан аваад, Өөлд хэмээн нэрийджээ. Баатар убаши түмний туурвисан "Дөрвөн Ойрадын түүх"-д: "...Дөрвөн ойрад гэхийн нэг нь Өөлд" (Хошууд ноён Баатар убаши 1976:2) гэжээ.

Өөлдүүд өөрсдийнхөө гарлыг ууль шувуутай холбон тайлбарлана. Галдан туслагчийн "Эрдэнийн эрих"-д: "...Нэгэн зүйл. Дөрвөн Ойрад Өөлдийн уг болбоос хурмаст тэнгэрийн хүүхэн энэ замбутивд агар зандан модны ёроолд мэндэлсэн бөгөөд мөн зандан модноос өлгөн тавьсанд тэр модны навчинд хурын ус орсноор ундаалан, бас модны үзүүрт нэгэн ууль шувуу донгодож буй лугаа саатаж байсан ба бас модны ёроолд буй аягат ус сэлтээр авч тэр хөвгүүнийг үргүй өвгөн эмгэн хоёр асарч агар зандан модоор өлгий засаж тэжээн өсгөж Хотгойд Догшин хар ноён хэмээн нэрийдсэнээр Өөлд бус Өлэгэд овог хийгээд Дөрвөн Ойрад Өлэгэд ястан үүнээс үүсчээ" (Галдан туслагч 2010: 133) гэж бичсэн буй.

Ховдын Өөлдийн дунд тархсан нэгэн домгийг сийрүүлбээс: "Эрт урьдын цагт их ой модтой, ой мод нь жир жимстэй нэгэн сайхан нутагт цөөн бог малтай үр хүүхэдгүй өвгөн, эмгэн хоёр амьдран суудаг байжээ. Намрын нэг өдөр өвгөн ой дотор хонь, ямаагаа хариулан явж байж. Гэтэл модон дотор нэг ууль шувуу дуугарч сонсогдож гэнэ. Өвгөн намар цагт ууль шувуу яагаад өдөр дуугарч байдаг билээ гэж гайхаж, шувуу дуугарч буй газар очиход, модны мөчирт өлгөсөн манцуйтай хүүхэд уйлж байх бөгөөд модонд ургасан жимсний шүүс дуслан гоожиж, хүүхдийн аманд орж ундалж буйг үзэж их гайхан, гэртээ хариад эмгэндээ хэлж гэнэ. Эмгэн сонсоод өвгөн минь тэр хүүхдийг яагаад авч ирсэнгүй вэ? Үр садгүй та бид хоёрт тэнгэр бурхан үр хайрласан байна шүү. Та маргааш намайг дагуулаад яв. Хоёулаа тэр хүүхдийг авч ирж үрээ хийж авъя гэж хэлжээ. Маргааш нь өвгөн, эмгэн

хоёрыг очиход урьд өдрийн байдал хэвээр. Ууль шувуу дуугарсаар, модонд өлгөсөн манцуйтай хүүхэд уйлсаар л байж гэнэ. Тэр хоёр авч очсон идээнээсээ цацаж арц уугиулаад модонд цагаан өнгийн даавуу уяад хүүхдийг авч гэртээ иржээ. Хүүдээ өлгөөтэй байсан учир өлгөөд гэдэг нэр өгөөд ямааны сүүтээр тэжээж өсгөж гэнэ. Тэр хүүхэд эрэгтэй бөгөөд өсч том болоод айл орон болж, тэр хүүхдээс үүссэн өрх айл хүмүүсийг өлгөөдийнхөн гэдэг болжээ. Яван явсаар өлгөөд гэдэг үг нь өөлд болсон гэдэг. Тийм ч учраас өөлдүүд өдгөө ууль шувууг оролддоггүй, алдаггүй бөгөөд түүгээр ч үл барам:

Ууль шувуун эцэгтэй

Ургаа модон ээжтэй

Бал бурман мээмтэй

Зандан модон манцуйтай" (Намсрай 1989: 87) гэж хэлэлцдэг аж.

Өөрсдийгөө Өөлд хэмээн нэрлэдэг бүлэг хүмүүс Монгол, БНХАУ-д аж төрж байна. Тэд Манжийн түрэмгийллийг эсэргүүцсэн Галдан бошигт, Амарсанаа нарын тэмцлийн үед энд тэнд цацагдан үлдсэн, олзлогдсон, боол зарц болгон өргөсөн хүмүүс юм. Тэдний үр хойчис өдгөө Халхчуудын дотор олон газарт сууж өөрсдийгөө Өөлд хэмээн нэрийдсээр ирэв.

Профессор А.Очир "Өгэлэй гэдэг үгэнд олны-д нөхцөл нэмэхэд уг үгийн сүүлийн-и хураагдаад хэмээх угсаатны нэр үүсчээ" (Очир 2012: 160) хэмээн бичсэн байна.

Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын нутагт Харуул хайрхан уул гэж буй. Түүнийг нутгийнхан Өөлдийн цэргийн харуул сууж байсан нутаг хэмээдэг. Түүнээс гадна тус нутагт Өөлдийн сээр, Өөлдийн худаг хэмээх нэртэй газрууд бий.

Өрлөгчүүд (Өрлөгүүд): Профессор А.Очирын бичсэнээр өрлөгүүд гэдэг үгээс үүссэн нэр юм. Монгол хэлний өрлөгүүд хэмээх үг нь угтаа өрлөг хэмээх үгэнд олны-ууд нөхцөлийг залгаснаар үүсчээ хэмээн үзсэн байна. Монгол хэлэнд хоёр эгшгийн дундах -г гийгүүлэгч сугарч, хоёр эгшиг нь ижилсэж уртаар дуудагдах нь бий. Тэр ёсоор Өрлөгүүд хэмээх үгийн -г гийгүүлэгч гээгдээд өрлүүд болсон байна (Очир 2012: 161).

Өрлүүд нар нь XIII-XIV зууны үеийн болон түүнээс хожим үеийн жанжид, өрлөг цолт үр хойчис байж болох юм. Өдгөө эл овог Говь-Алтай аймгийн Баян-Уул суманд бүртгэгдээд байна (Очир, Сэржээ 1998: 16-17).

Сартуул: XIII-XIV зууны үед Монголчууд Хорезмын улсын захиргаан дахь ард иргэдийг Сартуул хэмээн нэрийддэг байв. Сартуул нь самгард гаралтай үг аж. Самгардаар худалдаачин гэдгийг "sart sartavaxi" гэдэг аж.

Гэвч судлаачид Сартуул хэмээх нэрийн гарал

үүсэл, угсаа гарал, түүхэн нутагшилтын асуудлаар янз бүрийн саналууд дэвшүүлсээр иржээ. Үүнд: профессор А.Очир Сартуул хэмээх үгийн гарлын талаар Самгарид хэлний сарт гэсэн үгэнд монгол ярианы хэлний уул нөхцөл залгаж, сартуул хэмээх нэр үүсгэсэн байлтай гэж үзжээ (Очир 2012: 163). Энэ бол зөвхөн нэрийн тухайд хэлсэн санал юм.

Эрдэмтэн Э.Вандуй: “Манай Сартуулын ахмад хүмүүсийн дунд үе улиран дамжиж ирсэн домгоос үзэхэд сартуул гэлэг үг бол ястны оноосон нэр биш, газар нутгийн нэр гэж хэлэлцдэг. Сартуул хошууны гол нутгийн зааг Цэцэн уул, Сарт Таван толгой гэдгийн нэрээр Цэцэн сартагула-Цэцэн Сартуул, сүүлдээ хураангуйлагдсаар зөвхөн Сартуул гэдэг болсон юм гэж Сартуулын өвгөд хөгшид бүр шахам ярьж байна” (Вандуй 1964) гэж бичжээ.

Эрдэмтэн Х.Нямбуу: “Далдан хөндлөнгийн өмчилж авсан Сартуул, Тангуд хоёр отгийн сартуулаас Цэцэн сартуул хэмээн нэгэн хошуу үүссэн нь Сарт уулыг тойрон төвлөрч нутаглажээ. Тэрхүү Сарт уул гэдэг нь Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт буй эртнээс тахилга тайлгатай байсан Сарт толгой хэмээх бяцхан уул болно” (Нямбуу 1992: 73) гэж тэмдэглэсэн байна.

Доктор Г.Пүрэвдорж Сартуул хэмээх үгийн гарлын талаар: “...Түүхэн сурвалж бичиг, архивын данс хараа, ноёдын хэрэглэж байсан гарын тэмдэг, бичгийн хүмүүсийн тэмдэглэл зэрэгт энэ нэр хэрхэн тэмдэглэгдэж ирснийг баримтаар тодруулж үзье хэмээгээд, Сэцэн засгийн хошууны сүүлчийн ноён Жалцангомбоцэдэнгийн хэрэглэдэг гарын тэмдэгт “Сарта-гол”, “Сартагол сэцэн вангийн гарын тэмдэг”, архивын данс хараанд “Тагц сартагол нэгэн хошуу”, “Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгуудын ван гүнгүүдийн илтгэл шастир”-т “Сарта голын газарт”, Сэцэн сартуул хошууны анхны дарга, төр, нийгмийн зүтгэлтэн Б.Ламжавын бичсэн монгол бичгээрх гар бичмэлд “сэцэн сартагол хошуу” хэмээн бичжээ. Энэ баримтуудад монгол бичгээр тэмдэглэн үлдээсэн байдал, хошуу ноён гарын тэмдэгтээ ийн оруулсан зэргээс харахад “Sartagool” гэж зориуд тодотгон ялгасан газар нутгийн нэр болох нь мэдэгдэнэ” (Пүрэвдорж 2019:48-49) гэж бичжээ.

Сартуулууд XIII зуунаас Чингис хааны удмын ноёдод захирагдан явсаар XVI зууны дундуур Гэрсэнзийн ууган хүү Далдан хөндлөнгийн мэдэлд очжээ. Улмаар Хангай уулын баруун хэсгээр нутаглаж байгаад Халхын Засагт хан аймагт захирагдах болов.

Бидний судалгаагаар Сартуул овог Говь-Алтай аймгийн Хөхморьт суманд нэмж бүртгэгдлээ.

Тангуд: Чингис хаан 1205-1226 онд Тангуд руу дөрвөн удаа довтлон байлдан мөхөөжээ. Тэд байлдааны явцад Тангудаас тэмээ, мал, янз бүрийн эд агуурс булаан авахын зэрэгцээ хүн амын заримыг нь

олзлон нутагтаа авчирчээ.

XIII зууны эхэн үед Монгол газар ирсэн Тангудууд Чингис хааны угсааны ноёдод захирагдсаар XV зуунаас Зүүн Монголын Халх түмэнд багтаж яваад, XVI зууны дунд үеэс Халхын арын долоон отгийн бүрэлдэхүүнд орж, Гэрсэнзийн 6 дугаар хүү Далдан хөндлөн болон түүний үр хойчсын мэдэлд шилжжээ. Тэр цагт Тангуд нар Хангай уулаар нутаглаж байв (Очир 2012: 125).

1662 онд Далдангийн удмын Бинт ноён өөрийн харьяат ардуудыг дагуулан, Өвөр Монголд нүүн очсонд, Манжийн эрх баригсад тэднийг Зостын чуулганы Түмэд зүүнгарын хошуунд хавсарган суулгав. Тэгж Өвөр Монголд Тангуд халх нэртэй нэгэн хошуу буй болжээ.

Тангуд нарын дийлэнх олонх нь хэдийгээр тийнхүү нүүн явсан боловч зарим нь бас халхчуудын дотор үлдсэн аж. Тэд сарнин тархаж, халхын янз бүрийн хошуудад орж нутаглаад, өөрсдийгөө тангуд овогтон гэх болжээ. Тангуд нар өнөөгийн Монгол улсын Говь-Алтай аймгийн Хөхморьт, Баян-Уул суманд аж төрж буй буй. Говь-Алтай аймгийн Баян-Уул суманд буй Тангуд овгийнхон ах дүү гурван хүнээс салбарлан үүссэн хэмээн ярьж байлаа. 1950-1960-аад оны үед тус суманд Тангуд овгийн нэлээд олон өрх байсан гэдэг.

Тугчин: Монголчууд эрт дээр үеэс адууны хялгасанаар туг хийж, түүнийгээ эрхэмлэж тахидаг байв. Туг тахиx ёс нь бөөгийн зан үйлээс үүдэлтэй бөгөөд XX зууны 30-аад он хүртэл Ар, Өвөр Монгол, Ойрадын олон газарт байжээ. Цагаан адууны хялгасаар хийснийг цагаан туг, бараан хялгасаар хийснийг нь хар туг, цагаан, бараан адууны хялгасыг хольж хийснийг алаг буюу буурал туг гэхчлэн нэрлэнэ. Тугийг тусгайлан байрлуулж хадгалдаг гэрийг “тугийн гэр”, “тугийн өргөө” хэмээнэ.

Бидний судалгааны явцад Говь-Алтай аймгийн Хөхморьт, Баян-Уул сумдад бүртгэгдлээ. Тугчин, Тугтан овог бол хар туг хадгалж, тахиж тайдаг хүмүүсийн үр удам бололтой. Засагт хан аймгийн Баатар засгийн хошуунд эрт цагаас буурал сүлдийг тахисаар иржээ. Биднийг судалгаа хийж байхад Баян-Уул суманд Тугчин, Тугтан овгийн хүмүүс хэд хэд тааралдав. Овгийн талаар асуухад сүлдний тахилга хийдэг байсан хүмүүсийн үр удам гэнэ. Тугчин гэх нэр нь туг хэмээх үгэнд-чин хэмээх дагавар залгаж үүссэн бололтой.

Түүхч, архивч Ц.Сономдагва Баатар засгийн хошуунд бас Хартугчин овог байсныг дурдсан буй (Сономдагва 1998: 262). Энэ нь нь бас Тугчин овгийн нэг хэсэг бололтой.

Тугтан: Энэ овог Баатар засгийн хошууны хүн амын дотор байжээ. Бидний судалгааны явцад эл овгийн хүмүүс Говь-Алтай аймгийн Баян-Уул суманд нэмж бүртгэгдлээ. Туг хадгалж, тахиж тайж байсан

хүмүүсийн үр удам бололтой. Тугтан гэх нэр нь туг хэмээх үгэнд-тан хэмээх дагавар залгаж үүссэн байж болох юм.

Урианхан: Баатар засгийн хошуутай хил залган оршдог Засагт хан аймгийн Дайчин засгийн хошууг сурвалжид “Урианхай хошуу” хэмээн бичжээ. Баатар засгийн хошуунд Урианхан овогтон нар бас аж төрж байв. Магадгүй тэд Дайчин засгийн хошуунаас орж ирсэн хүмүүс байж болох юм.

Урианхай нар нь хүн ам олонтой том аймаг байгаад XIII зууны үед хэд хуваагдан бутарч, XVI зууны үед Монголын хааны засаглалыг эсэргүүцэж бут цохигдоод олон газарт сарнин тархжээ. Гэвч тэдний бөөндүү үлдсэн хэсэг нь XVI зууны сүүлчээс баруун тийш нүүдэллэн, Хангай ууланд хүрч түр сууснаа, удалгүй Алтайд хүрч, XVII зуунд Халхын Засагт хан аймгийн бүрэлдэхүүнд багтжээ.

Одоогийн Монгол улсын бараг бүх аймагт Урианхан, Урианхай нар цөөн цөөнөөр тархан сууж буй нь судалгааны явцад илэрч мэдэгджээ. Эдүгээ ч Говь-Алтай аймгийн Хөхморьт, Баян-Уул сумдад Урианхан, Урианхай овогтон бүртгэгдлээ.

Хойд: Угсаатны судлалын хээрийн судалгааны явцад энэ овгийн хүмүүс Засагт хан аймгийн Баатар засгийн хошуунд буюу өнөөгийн Говь-Алтай аймгийн Баян-Уул суманд аж төрж буй нь мэдэгдэнэ.

Хойд бол Ойрадын язгуурын аймаг юм. XII-XIII зууны заагт тэдний тэргүүлэгч нь Хутуга бэхи байв. 1207 онд Зүчи Ойн иргэдийг эзлэхэд, Хутуга бэхи түмэн Ойрадын түрүүнд Зүчид элсэн, түүнийг газарчлан тусалжээ. Тэр үед Ойрадыг дөрвөн мянган болгоод, Их Монгол улсын баруун жигүүрт багтаажээ. Хутаг бэхи мянганы ноён болов. XIII зууны эхэн хагаст Хутуга бэхийн угсааны ноёд Чингис хааны алтан ургаас удаа дараа хатан буулгаж, бүсгүйчүүд нь хаад, язгууртанд бэр мордох зэргээр Хойд аймгийнхан нэр, нөлөө бүхий байлаа.

Хойд нар XIII зууны сүүлчээс XV зууны сүүлч хүртэл Завхан, Хүнгүй, Тэс голоор нутаглаж байснаа XVI зууны эхээр Зүүн Монголчуудад шахагдан, баруун тийш нүүж, мөн зууны дунд үед Хамийн зүүн хойнох Жалманхан уул хүрч суужээ. Тэд XV зууны үеэс Баатудтай хамт нутаглан, хоёул нийлж Дөрвөн Ойрадын нэг ойрад гэгдэх болжээ. Гэтэл Эсэн тайш Баатудын Алагтөмөр нар эе эвдэрснээс Баатуд нь бутраад Зүүн, Баруун Монголд сарнин тархжээ. Харин Хойдын хүн ам нь олшрон, аймгийн шинжийг хадгалсаар байлаа.

Чин улсын түрэмгийллийг эсэргүүцсэн Галдан бошигтын тэмцлийн үед Хойдын тайж Лувсанг хэсэг хүмүүсийн хамт Манж нар эрхшээлдээ оруулж, нэгэн хошуу болгоод Засагт хан аймагт захирган, Шаргын говь, Цагаан нуурын хойно, баруун хойгуур суулгав. Хойд нарыг бас “Шаргын өөлд” хэмээжээ. Хойд нар

Галдан, Амарсанаа нарын Манжийн түрэмгийллийг эсэргүүцсэн тэмцлийн үед ихээхэн тархан сарниж, Ойрад, Халхчуудын дунд энд тэнд цөөн цөөнөөр орж суув (Очир 2012: 247).

Ойрад аялгууны “хой” нь монгол бичгийн хэлний хонь гэсэн үг юм. Хонь гэсэн утга бүхий хой гэдэгт олон тооны-д нөхцөл залгаж, Хойд хэмээх нэр бүтээжээ (Очир 2012: 248).

Магадгүй эдгээр хойд овгийн хүмүүс дараах шалтгааны улмаас Засагт хан аймгийн Олхонууд гурван хошуунд орж ирсэн бололтой. Үүнд:

1. Галдан бошигтын тэмцлийн явцад үлдэж хоцорсон байж болно.

2. Засагт хан аймагт хавсаргасан Хойд хошуу болох Сүжигт засгийн хошуунаас Баатар засаг, Үйзэн засаг, Эрдэнэ засгийн хошуунд орж ирсэн байж болох юм.

Хойдуудын талаар сонирхолтой хэлц үг Засагт хан аймгийн халхчуудын дунд үлдэж хоцорчээ. Засагт хан аймгийн Баатар засгийн хошуунд:

Хойд олон ч хошуунд нэмэргүй

Хошлон урт ч хоолонд нэмэргүй хэмээдэг бол, Дайчин засгийн хошуунд:

Хош (хошног) хоолонд нэмэргүй

Хойдууд хошуунд нэмэргүй гэж хэлэлцдэг.

Хорхой нүдэн: Баатар засгийн хошуунд энэ овог байсан тухай А.Очир, Ж.Сэржээ, Ц.Сономдагва нар бүтээлдээ дурджээ (Очир, Сэржээ 1998: 16-17; Сономдагва 1998: 262).

Хотгойд: XVI зууны сүүл хагаст Халхын Засагт хан Лайхур ойрадад довтлон, Хойд аймгийн голдуу хүн амыг голдуу олзлон, Халхын баруун хэсэгт авчран Халхчуудтай хамт нутаглуулжээ. Тэд анхандаа Хангай уулын баруунаар нутаглаж агснаа аажмаар баруун тийш Увс нуур хүрэв. Лайхурын ач Шолой Убаши (1657-1627)-ийн үеэс тэд Засагт хан аймагт захирагдахгүй болж, харьцангуй биеэ даан оршин тогтноод “Алтан ханы улс” хэмээн нэрлэгдэх болов.

XVI зууны сүүлчээс Засагт хан аймгийн захиргаанаас гарсан Хотгойд нар улс төр, эдийн засгийн хүч нөлөө нь өсөхийн хирээр газар нутгаа өргөтгөн, зүүн тийш Сэлэнгэ, Тамир голын эх, баруунтаа Хархираа, Түргэний уул, умард этгээдэд Оросын Красноярскийн хязгаарт дөхөж очжээ. Шолой Убаши болон түүнийг залгамжлагчид Енисей мөрний Хиргис, Тагнын Тува, өмнөд Сибирийн Теленгидийн заримыг нөлөөндөө оруулан, ангийн үс зэрэг зүйлээр алба авдаг байжээ. Хотгойдын тэргүүлэгч Шолой Убашийн ач Лувсан өөрийн 1000 илүү харьяатаа дагуулан, 1686 онд Хөхнуурт очиж, Манжид дагаж оров. Хөхнуурт очсон түүний харьяат нар XVIII зууны эхээр буцан ирсэнд, манж нар тэднийг нэгэн хошуу болгоод, Лувсангийн хүү Намринчимбад захируулан, Засагт хан аймагт харьяалуулаад, Цогтой засгийн хошуу хэмээжээ. Хөхнуурт нүүлгүй нутагтаа үлдсэн

Хотгойд нарыг 1686 онд манж нар Шолой Убашийн жич Гэндэнд захируулав. Гэндэнгийн үрчилсэн хүү Бүүвэй 1717 онд Ойрадад довтлон, 1000 илүү хүн олзлон авчирч, хотгойдод нэгтгэжээ (Очир 2012: 258-259).

Манжийн дарангуйллын эсрэг тэмцсэн Хотгойдын ноён Чингүнжав 1756 оны сүүлчээр давуу хүчинд түрэгдэн, Оросын хил рүү ухрах үед Манжийн эрх баригсад өөртөө үнэнч Халхын ноёдод Хотгойдын хүн амыг хуваан өгч, Дүүрэгч засгийн хошуу, Далай засгийн хошуу, Ахай засгийн хошуу, Мэргэн засгийн хошууг байгуулжээ. Урьд нь байгуулсан Цогтой засгийн хошуутай нийлээд хотгойдын 5 хошууг Засагт хан аймагт захируулав. Хотгойд таван хошууны засаг ноёд, ихэнх тайж нар нь цөм Гэрсэнзийн ууган хүү Ашихайн угсааныхан юм.

Хотгойд нэрийн гарлын талаар судлаачид олон янзын санал дэвшүүлжээ. Үүнд: доктор С.Пүрэвжав: "...Ойрадаас авчирсан Хойд нар анхандаа баруун халхчуудын хойт талаар нутагладаг бөгөөд тэд бас ойрадын өвөрмөц аялгуугаар ярьдаг байсан. Тэгээд хойт талаар нутагтай гойд сонин хэл яриатай хүмүүс хэмээн тэднийг хойт гойд гэж хочилдаг байсан нь яваандаа хотгойд гэдэг нэр болсон" (Пүрэвжав 1970) гэжээ.

С.Чулуун: "... Бидний санахад тэд өөрсдийгөө эрхлэх аж ахуйтай холбон нэрлэсэн бололтой. Баруун монголын аман аялгуунд хонийг хой буюу кой хэмээн нэрлэх бөгөөд Хойдууд нь Халхын Засагт ханы араар нутаглахад тэд эрхлэх аж ахуйн хувьд хониор нэн баян байсан мэдээ сурвалжид мэр сэр тааралдана. Өдгөө ч тэдэнтэй хил залгаа орших халхууд хонин хотгойдууд хэмээн хочлон нэрлэдэг. Бид үзэхдээ хой буюу хонь гэсэн үгэнд уугуул аймгийн нэр "Хойд"-ыг нийлүүлэн Хотогойд хэмээх нэр үүссэн болов уу гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл хой+т+хойд=Хотогойд хэмээн үүссэн бололтой" (Чулуун 2006: 43-44) гэж бичжээ.

Цахар: Зарим судлаачид Цахар овог Засагт хан аймгийн Баатар засгийн хошуунд байсан талаар тэмдэглэсэн байна (Очир, Сэржээ 1998: 16-17).

Юань улс унаж, Монголын язгууртнууд эх нутагтаа буцаж ирсний дараагаас Цахар хэмээх нэр түүхэнд гарч эхэлжээ. Тэд XV-XVI зууны үед Зүүн Монголын зургаан түмний нэг болж, хааны бие, орд өргөөг хамгаалах, зоос шүүс бэлтгэх, цэргийн гол хүчний үүргээ биелүүлж байв.

Ж.Төмөрцэрэн Цахар нь эхлээд монгол хаад, ноёдын орд харшийг нэрлэж байснаа дараа нь тэдний бие хамгаалагч, хаанд ойр дотно байж, торгон цэргийн үүрэг гүйцэтгэх хүмүүсийг нэрлэдэг болжээ (Төмөрцэрэн 1961: 111-115) гэжээ.

Цахар түмэн нь дотроо Хэшигтэн, Зүйд, Буруд (бүрд), Холбод, Найман, Сөнид, Үзэмчин, Хуучид, Аохан, Алагчууд, Цагаан татар, Хэмчигүд зэрэг

хэд хэдэн аймгаас бүрдэж байжээ (Очир 2012: 278). Монгол улсын нутагт илэрч мэдэгдээд буй Цахар нар нь цахар хэмээх ерөнхий нэрийн дор явсан дээрх аймгуудын үр сад байсан бололтой.

Дүгнэлт

Засагт хан аймгийн Баатар засгийн хошуунд халхчууд оршин суудаг бөгөөд тэднийг сурвалж зохиолд "Олхонууд хошуу" хэмээн нэрийдсэн буй. Тус хошуунд Авга, Алаг адуутан (Алаг адууныхан), Баарин, Баатад, Багш хиа нар, Боржигин, Бэсүд, Горлос, Дайчин, Дөчин, Еншөөбүү (Огтор Еншөөбүү), Жалайр, Зуухныхан, Их мянган, Олхонууд, Өөлд, Өрлөгчүүд (Өрлөгүүд), Сартуул, Тангуд, Тугчин, Тугтан, Урианхай, Хойд, Хорхой нүдэн, Хотгойд, Цахар зэрэг овгийнхон аж төрсөөр ирсэн нь угсаатны судлалын судалгааны явцад илрэн мэдэгдэж байна. Эдгээрийг гарал үүслийн хувьд авч үзвэл эртний сурвалжит монгол овог, хожуу үүссэн овог, ойрадаас гаралтай овгуудаас бүрдэж байна.

Abstract

The tribal composition of the Khalkh people of Baatar zasag's khoshuu of Zasagt khan aimag

Baasankhuu Batmunkh

Khalkhs occupy 80 percent of the population of modern Mongolia. Khoshuu of Baatar zasag's was established in 1691. Located present-day Khokhmorit and Bayan-Uul sums of the Govi-Altai aimag. That is why the in historical source calls the "Olkhonuud khoshuu".

In this article dealt about the origin and tribal composition of the Khalkhs of Baatar zasag's khoshuu in Zasagt Khan aimag. Many tribes live in Baatar zasag's khoshuu of Zasagt Khan aimag, such as Alag Aduun, Besud, Borjigin, Jalair, Olkhonuud, Sartuul, Khotogoid and Uriyankhai who became the ancestors of the khalkhs.

Keywords: Zasagt khan aimag, Baatar zasag's khoshuu, people, tribe

Ном зүй

БНМАУ-ын угсаатны зүй, (1987). Халхын угсаатны зүй I боть. Редактор С.Бадамхатан. УБ.

Вандуй, Э. (1964). Завханы сартуул ба түүний аман аялгуу. *Хэл зохиол судлал* Т-II F-17 УБ.: 89-211.

Галдан туслагч, (2010). Эрдэнийн эрих хэмээх түүх болой. Эрдэм шинжилгээний удиртгал, хөрвүүлэг, тайлбар бичсэн Дуутан Жамсранжавын Гэрэлбадрах. Редактор Ё.Жанчив. УБ.

Зарлигаар тогтоосон ... (1997). Зарлигаар тогтоосон Монгол улсын шастирын хураангуй. Кирилл бичигт буулгаж, хэвлэлд бэлтгэн, тайлбар хийсэн А.Очир, З.Лонжид, Ц.Төрбат Тэргүүн боть. УБ.

Монгол ард ... (1979). Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас. Атласыг ерөнхийлэн эрхэлсэн доктор, академич Б.Ринчен. Тэргүүн дэд боть боть. УБ.

Мөнхтөр, Л. (1979). Хөхморьт их толь. Ерөнхий редактор Д.Цахилгаан. УБ.

МНТ, (2011). Монголын нууц товчоо. Сонгомол эх. УБ.

Очир, А. (2002). Халхын арын долоон отгийнхны угсаатны бүрэлдэхүүн, гарал, тархац. Төв Азийн нүүдэлчдийн угсаатны түүхийн асуудал. УБ.: 11-94.

Очир А., Гэрэлбадрах, Ж. (2003). Халхын Засагт хан аймгийн түүх. УБ.

Намсрай, Н. (1989). Өөлдийн гарал, зан заншлын тухай. *Studia historica*, Tom XXIII Fasc-10 УБ.: 87-100.

Нямбуу, Х. (1992). Монголын угсаатны зүйн удиртгал. УБ.

Пүрэвдорж, Г. (2019). Засагт хан аймгийн Сэцэн Сартуул хошуу. Хянан тохиолдуулсан Г.Цэрэнханд. УБ.

Пүрэвжав, С. (1970). Хотгойдын угсаа гарал ба түүхийн асуудалд (XVI-XIX зуун). УБ.

Рашид-Ад-Дин, (1952). Сборник летописей М-Л.

Сономдагва, Ц. (1998). Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт, шинэчлэлт (1691-1997) Нэмж засварласан II дахь хэвлэл. Нэмж засварласан Ч.Банзрагч, О.Батсайхан. УБ.

Очир, А. (2012). Монголчуудын гарал, нэршил.

Хоёрдахь хэвлэл. Эрхилэн нийтлүүлсэн: профессор Шаравын Чоймаа. УБ.

Очир, А., Сэржээ, Ж. (1998). Монголчуудын овгийн лавлах. Эрхлэн нийтлүүлсэн дэд доктор Тайжиуд Д.Цэдэв. УБ.

Төмөрцэрэн, Ж. (1976). Цахар хэмээх үгийн учир. *SM [Монгол судлалын зарим асуудал]*. Т-III, Fasc.1. УБ.: 111-115.

Хошууд ноён, (1976). Хошууд ноён Баатар убаши түмний туурвисан Дөрвөн Ойрадын түүх. *Тод үсгийн дурсгалууд*. Ботийн редактор Х.Лувсанбалдан. CSM., Tom XIX, УБ.

Чулуун, С. (2006). Хотогойдын түүх (XVII-XX зууны эхэн үе) Редактор Ө.Энхтүвшин. УБ.

Энэ нэгэн, (2006). Энэ нэгэн дэвтэр амуй. Галиглаж, хэвлэлд бэлтгэсэн Ж.Гэрэлбадрах. МНМ Tom II, Fasc. 1. УБ.

МНТ (1990). Монголын Нууц Товчоон. Худам монгол бичгээр утга судлалын үүднээс Шанжментавын Гаадамба төсөөлөн нягталж, сэргээсэн сийрүүлэг эх, тайлбар. УБ.

Received: May 6, 2025; Revised: June 1, 2025; Accepted: June 10, 2025

